

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ЗУРГААДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны хоёрдугаар сарын 18-ний 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 06 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 01 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</li><li>- Говьсүмбэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</li><li>- УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</li><li>-</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35<sup>1</sup> дугаар зүйлийн 35<sup>1</sup>.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Домбонгийн Үүрийнтуяаг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

		<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Давдайн Тамирыг Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Батсуурьт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p>
--	--	---

		<p>Бадралын Төгөлдөрийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Зарим ажилтныг удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар</li> <li>- Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар</li> </ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 03 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Бямбажавын Ганбатыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн</p>

		<p>тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 04 дүгээр дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Баярсайханы Тунгааг Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Артагт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

		<p>1. Төрийн албаны зөвлөлийн Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Гааль, татварын ерөнхий газрын дарга</li><li>2. Дэд дарга /Гаалийн асуудал хариуцсан /</li><li>3. Дэд дарга /Татварын асуудал хариуцсан/</li><li>4. Дэд дарга /Боомт нийтлэг үйлчилгээний асуудал хариуцсан/</li><li>5. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,</li><li>6. Хууль, эрх зүйн газрын дарга,</li><li>7. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,</li><li>8. Хүний нөөцийн хэлтсийн дарга,</li><li>9. Хүний нөөцийн хэлтсийн улсын байцаагч</li></ol> <p>2. Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон тооны гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/580 тоот албан бичгээр</p>
--	--	--

		<p>ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1 Төрийн албаны зөвлөлийн Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус газрын Хүний нөөцийн хэлтсийн улсын байцаагч Нямдоржийн Ууганбаярыг 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс томилох</p> <p>2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Ууганбаярт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Архангай, Дорнод аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 01 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд Архангай аймаг, Дорнод аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

		<p>1. Архангай аймаг, Дорнод аймагт 2016 оны 01 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 31 иргэн /Архангай аймагт 12, Дорнод аймагт 19/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 51 иргэн /Архангай аймагт 17, Дорнод аймагт 34/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 /Архангай аймагт 1, Дорнод аймагт 4/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэн /Архангай аймагт 4, Дорнод аймагт 4/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23</p>
--	--	---

		<p>дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл /Б.Лхагвасүрэн/-д, Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөл /П.Бат-Өлзий/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан Т.Ганжолоогоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>“Ёс зүйн хорооны дүгнэлтийн тухай” Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын Шүүхийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан Т.Ганжолоогоос гаргасан өргөдлийг хянан шалгахаар Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тушаалаар томилогдсон Маргаан хянан шалгах комиссын МХШҚД.02 дугаар дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн</p>



		<p>хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын "Нэг" дэх хэсгийн 3.6- д заасныг удирдлага болгон:</p> <p>1. "Албан тушаалаас халах тухай" Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Сум дундын 18 дугаар шүүхийн Тамгын газрын дарга Т.Ганжолоод Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-т заасныг үндэслэн төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулсан нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дахь хэсэгт заасныг зөрчсөн байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. "Албан тушаалаас халах тухай" Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцож шийдвэрлэхийг тус Зөвлөлд уламжлах.</p> <p>3.Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Зам тээврийн яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс 2016 оны нэгдүгээр сарын 11-нд зохион байгуулсан сонгон шалгаруулалтыг хянан шалгасан тухай	"Тайлбар гаргах тухай" 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02/481 тоот албан бичиг, холбогдох бичиг баримтаас үзэхэд сонгон шалгаруулалтыг

		<p>цахим хэлбэрээр зохион байгуулаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан шударга ёс, тэгш байдлын болон мөн зүйлийн 4.2.2-т заасан ил тод байх зарчим, 4.2.4-т заасан “иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх” зарчмыг зөрчсөн байна гэж дүгнэж, 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож сонгон шалгаруулалтаа цахимаар зохион байгуулах арга хэмжээг 2016 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв.</p>
--	--	---

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

